МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН 2022 ОНЫ ХАВРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 15-НЫ ӨДӨР /БААСАН ГАРАГ/-ИЙН НЭГДСЭН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН ТОВЬЁГ

№	*Баримтын агуулга*	Хуудас
	Хуралдааны товч тэмдэглэл:	1-18
	Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:	19-
	1.Хуулийн төсөл эцэслэн батлах санал хураалт /Гол нэр төрлийн зарим бараа, бүтээгдэхүүний үнийн өсөлт, хомстлоос сэргийлэх, сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төсөл/	21-23
	3.Улсын бүртгэлийн ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2022.03.11-ний өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/ Зарчмын зөрүүтэй 3 саналтай	23-26
	4.Хуулийн төсөл эцэслэн батална /Тагнуулын байгууллагын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд/	26-28
	5.Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль /Шинэчилсэн найруулга/-тай бусад хууль тогтоомжийг нийцүүлэх зорилгоор боловсруулсан хуулийн төслүүд /Засгийн газар 2022.01.05-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/	28-53
	6.“Хянан шалгах түр хороо байгуулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Улсын Их Хурлын гишүүн Б.Баттөмөр нарын 20 гишүүн 2022.04.06-ны өдөр өргөн мэдүүлсэн/	53-56

Монгол Улсын Их Хурлын 2022 оны хаврын ээлжит чуулганы 04 дүгээр сарын 15-ны өдөр /Баасан гараг/-ийн нэгдсэн хуралдааны товч тэмдэглэл

Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 76 гишүүнээс 39 гишүүн хүрэлцэн ирж, 51.3 хувийн ирцтэйгээр хуралдаан 10 цаг 03 минутад Төрийн ордны "Их хуралдай" танхимд эхлэв.

Томилолттой: А.Адъяасүрэн, Ц.Анандбазар, Д.Бат-Эрдэнэ, Б.Баярсайхан, Б.Бейсен, Х.Нямбаатар, Н.Учрал;
Чөлөөтэй: Н.Алтанхуяг, Т.Аюурсайхан, Х.Болорчулуун, Г.Дамдинням, Л.Оюун-Эрдэнэ, Ж.Чинбүрэн;
Эмнэлгийн чөлөөтэй: Х.Баделхан, Н.Ганибал, Ц.Мөнхцэцэг, Ш.Раднаасэд, Ч.Ундрам;
Тасалсан: С.Батболд, Г.Ганболд, Ж.Мөнхбат;
Хоцорсон: С.Ганбаатар-39 минут, Д.Ганбат-26 минут, Б.Жавхлан-14 минут, Д.Өнөрболор-33 минут, Ц.Сэргэлэн-18 минут, Ц.Туваан-28 минут, С.Чинзориг-10 минут.

Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Ц.Нямдоржоос "Хувийн эрх зүйн шинэтгэлийн бодлогыг хэрэгжүүлэх үйл ажиллагааны талаар" хийх Ерөнхий сайдын мэдээллийг хойшлуулах тухай албан бичиг ирүүлснийг танилцуулж, мэдээллийг хойшлуулав.

Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4-т заасны дагуу Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдоржоос ирүүлсэн албан бичгийг танилцуулж, Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдорж үг хэлэв.

Нэг.Хуулийн төслүүдийг эцэслэн батлах

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Э.Түвшинжаргал, Хууль, эрх зүйн газрын дарга Г.Агар-Эрдэнэ, мөн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Л.Батмөнх, Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Эдийн засгийн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Д.Мягмарцэрэн, референт Б.Ууганцэцэг нар байлцав.

Гол нэр төрлийн зарим бараа, бүтээгдэхүүний үнийн өсөлт, хомстлоос сэргийлэх, сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд:

Г.Занданшатар: 1.Гол нэр төрлийн зарим бараа, бүтээгдэхүүний үнийн өсөлт, хомстлоос сэргийлэх, сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн төслийг

эцэслэн батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 38
Татгалзсан: 8
Бүгд: 46
82.6 хувь буюу нийт гишүүний олонхын саналаар дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Д.Сарангэрэлийн “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

Г.Занданшатар: Улсын Их Хурлын гишүүн Д.Сарангэрэлийн гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 37
Татгалзсан: 9
Бүгд: 46
80.4 хувийн саналаар дэмжигдлээ.

Г.Занданшатар: Гол нэр төрлийн зарим бараа, бүтээгдэхүүний үнийн өсөлт, хомстлоос сэргийлэх, сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн төслийг эцэслэн батлах санал хураалтыг дахин явуулъя.

Зөвшөөрсөн: 38
Татгалзсан: 8
Бүгд: 46
82.6 хувь буюу нийт гишүүний олонхын саналаар дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Ц.Даваасүрэнгийн “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

Г.Занданшатар: Улсын Их Хурлын гишүүн Ц.Даваасүрэнгийн гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 40
Татгалзсан: 8
Бүгд: 48
83.3 хувийн саналаар дэмжигдлээ .

Г.Занданшатар: Гол нэр төрлийн зарим бараа, бүтээгдэхүүний үнийн өсөлт, хомстлоос сэргийлэх, сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн төслийг эцэслэн батлах санал хураалтыг дахин явуулъя.

Зөвшөөрсөн: 42
Татгалзсан: 6
Бүгд: 48
87.5 хувь буюу нийт гишүүний олонхын саналаар хууль батлагдлаа.

Хамт өргөн мэдүүлсэн:

2.Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 44
Татгалзсан: 4
Бүгд: 48
91.7 хувь буюу нийт гишүүний олонхын саналаар хууль батлагдлаа.

3.“Тогтоолд нэмэлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг эцэслэн батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 43
Татгалзсан: 5
Бүгд: 48
89.6 хувь буюу нийт гишүүний олонхын саналаар тогтоол батлагдлаа.

Уг асуудлыг 10 цаг 18 минутад хэлэлцэж дуусав.

Нээлттэй хуралдаан 15 минут үргэлжилж, 76 гишүүнээс 65 гишүүн хүрэлцэн ирж, 85.5 хувийн ирцтэйгээр 10 цаг 20 минутад хуралдааныг хаалттай горимд шилжүүлэв.

Хаалттай хуралдаанаар Тагнуулын байгууллагын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн эцсийн хэлэлцүүлгийг явуулав.

Хаалттай хуралдаан 34 минут үргэлжилж, 10 цаг 54 минутад хуралдааныг нээлттэй горимд шилжүүлэв.

ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Хууль эцэслэн батална. **Гол нэр төрлийн зарим бараа бүтээгдэхүүний үнийн өсөлт, хомстлоос сэргийлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүдийг эцэслэн батлах санал хураалт явуулна.**

Байнгын хороо эцэслэн батлах төслийн хувилбарыг бэлтгэж гишүүдэд тараасан байгаа.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 44.2-т заасны дагуу нэгдсэн хуралдаанаар хуулийн төслийг эцэслэн батлах бөгөөд Улсын Их Хурлын нийт гишүүний олонх дэмжсэн бол хууль эцэслэн баталсанд тооцно гэж заасан. Өөрөөр хэлбэл 39-өөс дээш олон гишүүн эцэслэн батлах ёстой.

Эцсийн хэлэлцүүлгийг өчигдөр явуулж дуусан байгаа. Ингээд Гол нэр төрлийн зарим бараа бүтээгдэхүүний үнийн өсөлт хомстлоос сэргийлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулна.

Найруулгын санал гэж байхгүй. Энэ эцсийн найруулга сонсоход эцсийн найруулга сонсох дээр найруулга дээр.

Бүртгэлийн санал хураалт явуулаад эхэлнэ. 39-өөс дээш гишүүн байж энэ хууль батлах ёстой шүү.

Энэ чинь 38 гишүүн санал өгсөн байна. Энэ сая бүртгэлийн санал хураалт явуулсан. Нийт 47 гишүүн байна. Сая бүртгэлийн санал хураалт гэж зарлаад санал хураалт явуулсан. Баатарбилэг гишүүн, Хүрэлбаатар гишүүн, Пүрэвдорж гишүүн энэ хуулийг эсрэг санал дарагдаад байна шүү.

Одоо санал хураалт явуулъя. Гишүүд анхааралтай байгаарай.

Гол нэр төрлийн зарим бараа бүтээгдэхүүний үнийн өсөлт, хомстлоос сэргийлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя.

Гишүүдийн 82.6 хувь нь дэмжсэн боловч энэ эцэслэн батлахад нэг санал дутаад байна.

Даваажанцангийн Сарангэрэл гишүүн горимын санал гаргана. Энэ хоёр сайд Сайнбуянгийн Амарсайхан, Лувсанцэрэнгийн Энх-Амгалан сайдын Засгийн газраас өргөн мэдүүлсэн хууль дээр, хуулийг эцэслэн батлах дээр эсрэг санал өгөөд байх юм.

Чимэдийн Хүрэлбаатар Төсвийн байнгын хороон дарга.

Сарангэрэл гишүүн.

Д.Сарангэрэл: Сая техникийн саатлын улмаас зарим гишүүдийн кноп ажиллаагүй учраас саяын санал хураалтыг хүчингүй болгож дахин санал хураалт явуулах санал гаргаж байна.

Г.Занданшатар: Сарангэрэл гишүүний санал саяын эсрэг гарчихсан байсан. Ингээд горимын саналаар санал хураалт явуулъя. Даваажанцангийн Сарангэрэл гишүүний гаргасан саяын санал хураалтыг хүчингүйд тооцох санал хураалт явуулъя.

80.4 хувийн саналаар саяны санал хураалтыг хүчингүйд тооцлоо.

Одоо санал хураалтыг дахиж явуулна. Өнөөдөр хэлэлцэж батлах ёстой хууль байгаа.

Одоо санал хураалт явуулна. Саяын санал хураалтыг хүчингүйд тооцсон учраас.

Энэ танхимд 44 гишүүн байна шүү. Тэгээд эсрэг санал. Одоо ингээд санал хураалт явуулна. Энэ Засгийн газрын хуралдаантай байгаа юм шиг байна.

Санал хураалт явуулна. Гол нэр төрлийн зарим бараа бүтээгдэхүүний үнийн өсөлт, хомстлоос сэргийлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя.

Цэрэнпилийн Даваасүрэн гишүүн.

Ц.Даваасүрэн: Сая санал хураалт дээр миний кноп ажилласангүй. Тэгээд өчигдөр бас ингэсэн юм. Хамгийн сүүлийн санал хураалт дээр бас.

Г.Занданшатар: Даваасүрэн гишүүнийх эсрэг гарсан юм.

Ц.Даваасүрэн: Би нэг их худлаа хэлээд байх ямар шаардлага байгаа юм Пүрэвдоржоо. Өчигдөр бас ингэсэн шүү. Тэгэхээр энэ дээр жоохон анхааралтай.

Г.Занданшатар: Техникийн саатал гараад байна.

Даваасүрэн гишүүний гаргасан горимын саналаар санал хураалт явуулъя. Саяын санал хураалтыг техникийн саатлын улмаас хүчингүйд тооцох санал хураалт явуулж байна.

40 гишүүн дэмжиж, 83.3 хувийн саналаар энэ саналыг хүчингүйд тооцлоо.

Ингээд санал хураалт явуулъя. Энэ техникийнхэн хяналтыг сайн тавиарай. Санал хураалтад бэлдээрэй.

Гол нэр төрлийн зарим бараа бүтээгдэхүүний үнийн өсөлт, хомстлоос сэргийлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя.

Танхимд 48 гишүүн байна. Санал хураалт.

42 гишүүн дэмжиж, энэ хууль эцэслэн батлагдлаа.

Пүрэвдорж гишүүн ээ, хууль эцэслэн батална гэдэг бол Үндсэн хуульд заасан Улсын Их Хурлын гишүүний журамт үүрэг байгаа шүү.

Хамт өргөн мэдүүлсэн Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя.

44 гишүүн дэмжиж, энэ хууль эцэслэн батлагдлаа.

Хоёр. Тогтоолд нэмэлт оруулах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг баталъя гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя.

43 гишүүн дэмжиж, хууль эцэслэн батлагдлаа.

Гишүүд, ажлын хэсэгт баярлалаа. Хуулийг хугацаанд нь эцэслэн баталлаа.

Одоо дараагийн асуудалд орно.

Тагнуулын байгууллагын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд. Засгийн газраас өргөн мэдүүлсэн эцсийн хэлэлцүүлгийг явуулна.

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 22.2-т хаалттай хэлэлцэхээр хуульд заасан болон төрийн нууцтай холбоотой асуудлыг хаалттай хуралдаанаар хэлэлцэнэ гэж заасны дагуу хуралдааныг хаалттай горимд шилжүүлнэ.